



NET CAPITAL  
financial group

# ANNUAL REPORT

NETCAPITAL 2022



[www.netcapital.mn](http://www.netcapital.mn)

# АГУУЛГА.

Netcapital Annual Report 2022



○ ТУЗ-ийн даргын мэндчилгээ	3
○ Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	4
○ Шагнал урамшуулал	5
○ Компанийн засаглал	6
○ ТУЗ-ийн гишүүдийн мэдээлэл	8
○ Санхүүгийн үзүүлэлт	12
○ Макро эдийн засгийн төлөв	13
○ ББСБ-ын салбарын судалгаа	14
○ Эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйл	17
○ Хүний нөөцийн бодлого, сургалт хөгжил	18
○ Компанийн ололт амжилтууд	24
○ Дижитал шилжилт	30
○ 2022 оны онцлох ажлууд	32
○ Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг	41
○ Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа	42

# ТУЗ-ИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ.

## Д.Алтангэрэл

ТУЗ-ИЙН ДАРГА


Өнгөрсөн жилүүд цар тахлын нөлөө их байсан ч амжилт бүтээлийн арвин олзтой, арга барил дижитал шилжилтийн хурдасгуур нэмэгдсэн сорилтын жил болж өнгөрлөө. Бид ч гэсэн энэхүү хурдтай өөрчлөлтөөс хоцролгүй, компанийн бүтэц зохион байгуулалт, дотоод болон гадаад өөрчлөлтүүдийг шат шатандaa оруулж хагас технологийн компани болон бэлтгэгдэж ажиллалаа.

2022 онд стратегийн хүрээнд Орон нутагт жишиг бүхий 12 салбараа нээж, шинээр 100 гаруй ажлын байрыг бий болголоо. Мөн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Чанарын Удирдлагын Тогтолцооны ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлсэн анхны ББСБ болж, Олон улсын мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO/IEC 27001:2013 стандартыг нэвтрүүллээ.

Корпорациын хэмжээнд зээлийн эрсдэлийг тархаан байршуулж, солонгорсон бүтээгдэхүүн хөгжүүлэлтүүдийг хийж, уламжлалт зээлийн үйлчилгээг дижитал хэлбэрт шилжүүлэн Дижитал гүүдс, Дижитал Мерчант, Дижитал кредит бүтээгдэхүүнүүдийг бүрэн хөгжүүлж, эрсдэлийн удирдлагын гурван шатлалт бүтцийг бий болгосон нь компанийн хэмжээнд зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийг салбарын дунджаас бага түвшинд барихад томоохон түлхэц болж өглөө.

Ирэх жилүүдэд бидэнтэй хамт байж санхүүгийн бүхий л төрлийн үйлчилгээг хариуцлагатай иргэн бүрд хүргэж, нийгмийн хүчирхэг дундаж давхаргыг бий болгох урт аялалд минь хамтдаа байж, амжилт өөд тэмүүлэх хүндэт харилцагч, хамтран ажиллагч байгууллагууд, ТУЗ-ийн гишүүд та бүхэндээ амжилт хүсэж, талархал илэрхийлье.

Хүндэтгэсэн "Нэткапитал финанс корпораци ББСБ" ХХК-ийн ТУЗ-ийн дарга Д.Алтангэрэл



## Гүйцэтгэх захирлын мэндчилгээ.

### Б.Хуншагай

Гүйцэтгэх захирал

Нэткапитал Финанс Корпораци ББСБ ХХК-ийн нийт харилцагчид, түншүүд та бүхэндээ 2022 оны тайлангаа танилцуулж байгаадаа туйлын таатай байна.

2022 онд Нэткапитал Финанс Корпораци ББСБ ХХК-ийн актив хөрөнгө 36 хувиар өсөж 109 тэрбум төгрөгт, татаан төвлөрүүлсэн хөрөнгө 45 хувиар өсөж 77 тэрбум төгрөгт, харилцагчдад олгосон зээлийн хэмжээ 26 хувиар өсөж 83 тэрбум төгрөгт тус тус хүрлээ. Бидэнд итгэл хүлээлгэн үйлчилгээ авдаг 40519 үнэнч харилцагч түншүүддээ болон байгууллагынхаа төлөө, харилцагч нарынхаа төлөө гэсэн сэтгэл, зүтгэлтэй 385 ажилтнууддаа талархал илэрхийлье.

Дижитал банкийг таны гарт алсын харааны хүрээнд дижитал шилжилтийг эрчимжүүлж нэг талаас бидний зүгээс тасралтгүй хөрөнгө оруулалт хийсний, нөгөө талаас харилцагчид маань шинэлэг зүйлийг хурдан хүлээн авч дэмжсэний үр дүнд маш богино хугацаанд Нэткапитал Финанс Корпораци ББСБ ХХК -ийн нийт харилцагчдын 80 хувь дижитал бүтээгдэхүүн, үйлчилгээний харилцагч боллоо.

Нэткапитал финанс корпораци ББСБ ХХК нь Ирэх 10 жилд Монголдоо төдийгүй олон улсад дижитал санхүүгийн үйлчилгээг үзүүлэх алсын хараатайгаар Монгол улсынхаа эдийн засагт өөрсдийн гэсэн хувь нэмрийг оруулж, хүчирхэг дундаж давхарга бүхий нийгмийг цогцлоо чин хүсэлдээ хөтлөгдөн ажиллаж байна. Хэдийгээр манай улсын эдийн засаг тогтвортгүй байгаа ч компанийн тогтсон систем, найдвартай хөрөнгө оруулагчид, эрхэм харилцагчид, мэргэжлийн хамт олныхоо хүчээр ирэх он жилүүдийг амжилттай даван туулж зорьсон зорилгоо биелүүлж, эх орондоо сайн сайхан үйлсийг бүтээж чадна гэдэгтээ итгэлтэй байна.

Хүндэтгэсэн "Нэткапитал финанс корпораци ББСБ" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Хуншагай

A handwritten signature in black ink, appearing to read "Б.Хуншагай".

# Шагнал урамшуулал.

Netcapital Annual Report 2022

Дэлхийн 200 гаруй улс оронд үншигчидтай, Олон улсын банк санхүүгийн салбарын мэдээ мэдээллийг хараат бус тэнцвэртэй байдлаар хүргэдэг онлайн сэтгүүл болох "Global Banking & Finance Awards"-аас жил бүр орон орны банк, санхүүгийн салбарын шилдгүүдийг тодруулдаг билээ.

Нэткапитал санхүүгийн группийг Монгол улсын Банк бус санхүүгийн байгууллагуудын хөгжлийг тодорхойлж, стратеги менежментээр шилдэг амжилтад хүрч, харилцагчийн сэтгэл ханамжид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэн, салбарын хурдасгуур болсон байгууллагад тодорхойлон 2021 оны "The Next 100 Global"-компаниар шалгарууллаа.

Цар тахлын хүнд хэцүү нөхцөл байдалд харилцагч, хөрөнгө оруулагч нарынхаа бизнесийн үйл ажиллагааг дэмжин, уян хатан нөхцөл бүхий бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэн ажилласныг батлан харуулж чадсан онцлох үйл явдал боллоо.

2022 онд:

- ✓ Зээлийн багц 26%
- ✓ Нийт хөрөнгө 37%
- ✓ Эх үүсвэрийн хэмжээ 45%-аар тус тус өссөн байна.

GLOBAL BANKING &  
**Finance**  
review®



Дижитал банкийг таны гарг



# Компанийн засаглал.

Netcapital Annual Report 2022

Нэткапитал Финанс Корпораци ББСБ ХХК нь Монгол Улсад бүртгэлтэй, хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр байгуулагдсан ББСБ бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжоос гадна банкнаас бусад зохицуулалттай салбарын зохицуулагч Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-оос баталсан Компанийн засаглалын кодексийг дагаж мөрдөх үүрэгтэй.

Бид 2022 онд шинэчлэгдэн гарсан “Компанийн засаглалын кодекс”-ийн дагуу ажиллах, засаглалын тогтолцоог үнэлж дүгнэх, цаашид сайжруулах тал дээр анхаарч ажиллалаа.

СЗХ-ны 2022 оны “Компанийн засаглалын кодексийн зайн үнэлгээ”-гээр Нэткапитал Финанс Корпораци ББСБ ХХК нь засаглалаараа тэргүүлэгч **ТОП-5 ББСБ-н нэг** боллоо.

Дижитал банкий



# Компанийн засаглалын кодескийн үнэлгээгээр салбартаа тэргүүлэгч ТОП-5 ББСБ

Санхүүгийн зохицуулах хороо 2022 оны 03-р сард шинэчлэн баталсан "Компанийн засаглалын кодекс"-ийн дагуу 2022 онд даатгал, ББСБ, хөрөнгө оруулалтын менежментийн компаниудад засаглалын зайны үнэлгээ хийж, засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээний тайланг гаргав.

"Нэткапитал Финанс Корпораци ББСБ" ХХК нь салбартаа компанийн кодексийн хэрэгжилтийн үнэлгээгээр тэргүүлэгч ТОП-5 ББСБ-н 1 боллоо.

## Компанийн засаглалын үнэлгээгээр тэргүүлэгч байгууллагууд



## Төлөөлөн удирдах зөвлөл.

2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт хувьцаа эзэмшигчдээс сонгогдсон төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") нь хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхэд хамаарахаар заасан асуудлуудаас бусад бүх асуудлаар шийдвэр гаргадаг.

ТУЗ-ийн даргын үүргийг хувьцаа эзэмшигч бус, хараат бус байр суурьтай гишүүн гүйцэтгэдэг ба ТУЗ-ийн бүрэлдэхүүнд банк, технологи, үл хөдлөхийн салбарын олон талын туршлагатай, ур чадвартай гишүүд ажилладаг.

Нийт гишүүдийн 70-с дээш хувь нь хараат бус гишүүн байдаг тул шийдвэр гаргалт хараат бус гардаг.

Д/д	Нэр	Албан тушаал
1	Доржрэнцэн <b>АЛТАНГЭРЭЛ</b>	ТУЗ-ийн дарга
2	Нэргүй <b>ҮНДРАХ</b>	ТУЗ-ийн гишүүн
3	Төрмөнх <b>ЖАВХЛАН</b>	ТУЗ-ийн хараат бус гишүүн
4	Лхагватөмөр <b>ОРГИЛ</b>	ТУЗ-ийн хараат бус гишүүн
5	Баатарзоригт <b>БОЛОРЧИМЭГ</b>	ТУЗ-ийн хараат бус гишүүн
6	Алтангэрэл <b>УРАНГОО</b>	ТУЗ-ийн хараат бус гишүүн
7	Санжаасүрэн <b>ОРГОДОЛ</b>	ТУЗ-ийн хараат бус гишүүн
8	Батчулуун <b>МӨНХЖАВХАА</b>	ТУЗ-ийн хараат бус гишүүн
9	Шарав <b>ЧУДАНЖИЙ</b>	ТУЗ-ийн хараат бус гишүүн

# ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮД.

Netcapital Annual Report 2022



## Д.АЛТАНГЭРЭЛ

ТУЗ-ИЙН ДАРГА

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2022 оноос компанийн ТУЗ-ийн даргаар сонгогдон ажиллаж байна. Мэдээллийн технологи, эрх зүйн чиглэлээр мэргэжилтэй ба 2008 оноос Монголын томоохон байгууллагуудад удирдах албан тушаал хашиж байсан туршлагатай.



## Н.УНДРАХ

ТУЗ-ИЙН ГИШҮҮН

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2020 оноос компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна. Банк, санхүүгийн мэргэжилтэй ба 1998 оноос хойш санхүүгийн салбарт ажиллаж байна. Монголын томоохон хувийн хэвшилийн байгууллагуудад удирдах албан тушаалыг хашиж байсан туршлагатай. 2008 онд компания үүсгэн байгуулж, удирдаж байна.



# ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД.

Netcapital Annual Report 2022



## Т.ЖАВХЛАН

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2021 оноос компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна. Банк, санхүүгийн салбарт 10 гаруй жил удирдах албан тушаалд ажилласан туршлагатай.



## Л.ОРГИЛ

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2022 оноос компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна. 2014 оноос хойш Банк, санхүү, даатгалын чиглэлээр ажиллаж байгаа туршлагатай.



## Б.БОЛОРЧИМЭГ

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2021 оноос компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна. 2012 оноос хойш Сэтгүүл зүйн салбарт ажиллаж байгаа туршлагатай.



## А.УРАНГОО

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2020 оноос компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна. 2013 оноос хойш үл хөдлөхийн салбарт бизнесээ эхлүүлж, энэ салбарт хуримтлуулсан арвин туршлагатай.

# ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД.

Netcapital Annual Report 2022



## Ш.ЧУДАНЖИЙ

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2020 оноос компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна. 1993 оноос хойш банк, санхүүгийн салбарт ажилласан бөгөөд Монголын томоохон банкуудад удирдах албан тушаалд ажиллаж байсан туршлагатай.



## С.ОРГОДОЛ

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2020 оноос компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна. 2008 оноос хойш банк, санхүүгийн салбарт ажиллаж байгаа бөгөөд монголын томоохон банкуудад удирдах албан тушаал хашиж байсан туршлагатай.



## Б.МОНХЖАВХАА


ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар 2022 оны 12 сараас компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгогдон ажиллаж байна. 2007 оноос хойш банк, санхүүгийн салбарт ажиллаж байгаа бөгөөд монголын томоохон банкинд удирдах албан тушаал хашиж байсан туршлагатай.

# Санхүүгийн гүйцэтгэл.


Netcapital Annual Report 2022

Нийт хөрөнгө, сая.₮




2022 онд нийт хөрөнгө 29тэрбумаар нэмэгдэж, 37% өсөв.

Зээлийн багц, сая.₮




2022 онд зээлдэгчийн тоо 14721-с 40519-д хүрч, 2.8 дахин өсөв.

Нийт эх үүсвэр, сая.₮



2022 онд эх үүсвэрийн харилцагчийн тоо 251-с 888-д хүрч, 3.5 дахин өсөв.



Цэвэр ашиг, сая.₮



2022 онд цэвэр ашиг 0.95 тэрбумаар нэмэгдэв.

# Макро эдийн засгийн төлөв.


Netcapital Annual Report 2022



- Монгол улсын ДНБ 2020 онд 4.6%-иар агшсан бол 2023 онд 5.6% тэлэх таамаглалтай байна.
- Цар тахлын нөлөөгөөр өрхийн хэрэглээ 6.6 хувиар багасаж, өрхүүд хуримтлалаа нэмэгдүүлж байснаар, эцсийн хэрэглээ буурсан гэсэн судалгааг Дэлхийн банк гаргасан.
- Хөгжлийн Банк 2022 онд Монгол улсын эдийн засгийн өсөлт 2.3% буюу нам төвшинд байх бол 2023 оноос илүү нэмэгдэх төлөвтэй хэмээн таамаглаад байна.

# ББСБ салбарын хөрөнгө, зээлийн багц, чанар.


Netcapital Annual Report 2022



- 2022 оны 3-р улирлын байдлаар ББСБ-ын нийт хөрөнгө 3.4 их наяд төгрөгт хүрсэн нь оны эхнээс 25.5%, өмнөх оны мөн үеэс 38.2% тус тус өссөн үзүүлэлт болсон байна.
- Тайлант хугацаанд нийт 522 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа ба нэг ББСБ-д ногдох дундаж хөрөнгө 6.5 тэрбум төгрөг байна. Харин Нэткапитал финанс корпораци ББСБ-ын нийт хөрөнгө салбарын дундажаас 16.7 дахин их байна.

# ББСБ салбарын хөрөнгө, зээлийн багц, чанар.

Netcapital Annual Report 2022




- ББСБ салбарын нийт зээлийн багц оны эхнээс 33%-иар өсөж, 2.5 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд нийт хөрөнгийн 74%-ийг эзэлж байна. Энэ нь банкны салбарын нийт хэрэглээний зээлийн багцын 42%-тай тэнцэхүйц үзүүлэлт юм.
- Нэткапитал финанс корпораци ББСБ-ын зээлийн багц 83.6 тэрбум төгрөгт хүрсэн нь салбарын зээлийн багцын 4 хувийг эзэлж байна.


# ББСБ салбарын хөрөнгө, зээлийн багц, чанар.

Netcapital Annual Report 2022

Чанаргүй зээлийн үлдэгдэл, тэрбум.₮



Зээлийн эрсдэлийн сан, тэрбум.₮



- Салбарын нийт зээлийн багцын 7.4% буюу 194.8 тэрбум төгрөгийн зээл чанаргүй зээлийн ангилалд байгаа бол Нэткапитал финанс корпораци ББСБ-ын хувьд 5.4% буюу салбарын дунджаас 2 пунктээр бага гарлаа.

- Салбарын байгуулсан нийт эрсдэлийн сангийн зардал нь салбарын чанаргүй зээлийн 73%-тай тэнцэж байна.
- Нэткапитал финанс корпораци ББСБ уг харьцаа 128% байгаа нь эрсдэлийн санг хангалттай байгуулсан, эрсдэл даах чадвар өндөр байгааг илтгэж байна.

# **Эрхэм зорилго, Алсын хараа, Үнэт зүйл.**

## **Эрхэм зорилго | Mission**

- ✓ Дижитал эринд финтек хувьслаар манлайлна

## **Үнэт зүйл | Value**

- ✓ Харилцагч төвтэй
- ✓ Өгөгдөл суурилсан шийдвэр гаргалт
- ✓ Платформ бизнес модель
- ✓ Ажайл байгууллага
- ✓ Бүтээгдэхүүнд суурилсан өсөлт

## **Алсын хараа | Vission**

- ✓ Дижитал банкийг таны гарта

## **Бидний соёл | Culture**

- ✓ Эерэг хандлага /Optimistic/
- ✓ Бүтээлч байдал /Creative/
- ✓ Нэг гэр бүл /One family/
- ✓ Залуу манлайлал /Young leadership/
- ✓ Тасралтгүй суралцах /Lifelong learning/
- ✓ Амжилтад тэмүүлэгч /Desire for success/



# Ерөнхий мэдээлэл.

Netcapital Annual Report 2022

Нэткапитал финанс корпораци ББСБ ХХК нь 2008 оны 09-р сарын 09-ний өдөр Монголын банк санхүүгийн салбарт зээл, хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрхтэйгээр үүсгэн байгуулагдсан. Монгол орон даяар 29 салбар нэгж, 380+ ажиллах хүч, **100,000+ харилцагч**, үйлчлүүлэгчтэйгээр 14 жил тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа санхүүгийн ууган компаниудын нэг юм.

## Хүний нөөцийн бодлого.

Бид алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйл, ёс зүйн дүрмийн хүрээнд хүний нөөцийн бодлого тодорхойлж компанийн хүн хүчний төлөвлөлт, хүний нөөц бүрдүүлэх, сонгон шалгаруулах, тогтоон барих, дасан зохицуулах, сургаж хөгжүүлэх, залгамж болон түлхүүр ажилтан бэлтгэх, байгууллагын бүтэц зохион байгуулалтыг тодорхойлон ажилладаг.

Бид ажилтныг бүрдүүлэх, сонгон шалгаруулах функцийг дээрээ хүний нөөцийн нээлттэй бодлого баримтлан ажилладаг. Байгууллагын зорилго ажилтан таны зорилготой нийцэж байхаар мэдлэг, ур чадвартай ажил горилогчийг "Зөв хүнийг, зөв албан тушаалд, зөв цагт" сонгон шалгаруулж авахыг зорин ажиллаж байна.

2021 оны эцсийн байдлаар Нэткапитал финанс корпораци ББСБ ХХК нь 155 идэвхтэй ажилтантай байсан бол 2022 оны 12 сарын байдлаар 385 идэвхтэй ажилтантай болж, 230 ажлын байрыг шинээр бий болголоо.

\*Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу ажилтны хүүхэд асрах чөлөөний хугацаанд тухайн ажлын байрыг хадгалж, хүснэгтээ өгснөөс 1 сарын дотор эргэн ороход шаардлагатай бэлтгэл ажлыг хангаж өгдөг.

# 385

Нийт идэвхтэй ажилтны тоо

# 135

Төв оффисын ажилтны тоо

# 147

УБ хотын салбарын ажилтны тоо

# 133

ОИ салбарын ажилтны тоо

# 8

Дээд шатны удирдлага

# 29

Нийт салбар



# Сургалт хөгжил.

Netcapital Annual Report 2022

- ✓ Манай байгууллага ажилтнуудаа хамрагдах түвшнээс нь хамааруулан сургалтын 70/20/10 зарчмыг хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд 70%-ийг ажлын дадлага туршлагаас, 20%-ийг харилцаа, үнэлгээ, коучинг, удирдах ажилтан болон хамт олны үлгэр дууриалал, зөвөлгөө чиглүүлгээр, үлдсэн 10%-ийг албан ёсны сургалтууд, танхимын болон онлайн сургалт, семинар, ном сурах бичгээс сурч хөгжих гэсэн агуулгатай.
- ✓ Чанарын удирдлагын тогтолцоо ISO9001:2015 стандартын хүрээнд бид нийт ажилтнуудынхаа ур чадварын болон талант үнэлгээг хийж байгууллагын өндөр гүйцэтгэлтэй болон өсөх ирээдүйтэй ажилтнуудыг тодорхойлох, ажилтнуудын карьер төлөвлөлтийг хийх, сургалт хөгжлийн үр дүнтэй хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж ажилладаг.
- ✓ 2022 онд 340 цагийн 33 удаагийн сургалтыг дотоодоос, 734 цагийн 34 удаагийн сургалтыг гаднаас авсан байна.
- ✓ Үүнээс 499 цагийн 28 сургалтыг ажилтан өөрөө бие даан хөгжүүлэх байдлаар оролцсон бол 575 цагийн 39 сургалтыг өөр бусад сургалтаар хамрагдаж хөгжүүлсэн байна.
- ✓ Сургалтын хэлбэрийн хувьд мэргэжлийн ур чадварын сургалт нийт 983 цагийн 54 сургалт, ерөнхий ур чадварын 87 цагийн 12 сургалт тус тус зохион байгуулж хамруулсан байна.
- ✓ ОН-н 90+ ажилтны хүрээнд “NETVIBE” сургалтыг зохион байгуулж цахим хэлбэрт оруулсан.
- ✓ Хотын 12 салбарт дотоод сургагч багш нар бэлтгэж Харилцагчийн Үйлчилгээний Стандартын сургалтыг 2 үе шаттайгаар зохион байгуулж цахим хэлбэрт оруулсан.
- ✓ Хотын салбарын 150+ ажилтны хүрээнд 10 газраас төлөөлөл болж 14 хоногийн хугацаанд 28 цагийн танхимын өглөөний сургалтуудыг зохион байгуулж, нийт сургалтыг цахим хэлбэрт оруулсан.
- ✓ Байгууллагын сэтгэлзүйн сургалтыг үе шаттайгаар зохион байгуулсан.
- ✓ Шинэ ажилтны дасан зохицуулах, чиглүүлэх хүрээнд шинэ ажилтны гарын авлага боловсруулж батлуулж үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.





## Компанийн соёлын хүрээнд.

Компанит ажил



Эерэгхандлага /Optimistic/

- Компанийн ажилтнуудын холбоо харилцааг нэмэгдүүлэх, эерэг хандлагыг түгээхээр **"Net Picnic 2022"** нийт ажилтны зуны зугаалга зохион байгуулагдav.



Бүтээлч байдал /Creative/

- Ажилтнуудынхаа бүтээлч байдлыг дэмжих, урамшуулахаар **"Net Creative"** TIK TOK уралдааныг амжилттай зохион байгуулав.



Залуу манлайлал /Young leadership/

- Компанийн 14 жилийн ойг тохиолдуулан ажилтнууддаа дээд шатны удирдлагуудын үлгэрлэл, манлайллыг бий болгохоор **"Net Leadership"** арга хэмжээг зохион байгуулав.



Нэггэр бүл /One family/

- Удирдлага, ажилтан хоорондын эргэх холбоог нэмэгдүүлэхээр **"CFR - Conversation, Feedback, Recognition"** уулзалтыг тогтмол хийж эхэллээ.
- Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан **"Net Family"** уралдааныг зарлаж, нийт ажилтнуудынхаа хүүхдийн авьяас, чадвар, амжилтыг таниулав.
- Нийт ажилтнуудын дунд спортын идэвхи оролцоог нэмэгдүүлэх, авхаалж самбааг сорих, багийн ажиллагааг дэмжихээр **"Net Cup"** спортын арга хэмжээг зохион байгуулав.



Тасралтгүй суралцах /Lifelong learning/

- Нийт ажилтнуудын дунд **"NET Podcast"** ном уншиж подкаст хийх **Жилийн аяныг** цахим хэлбэрээр хэрэгжүүлж эхэллээ.



# Бидний нэг болсноор.


Netcapital Annual Report 2022

- Эрэг дулаан уур амьсгалтай, тохилог таатай орчинд ажиллах
- Удирдлага-ажилтнуудын найрсаг жигд харилцаатай соёлд нэгдэх
- Залуу эрч хүчтэй, найрсаг хамт олны нэг болж тасралтгүй суралцах
- Олон улсад нэвтэрсэн сайн ажлын арга барилаас эзэмших
- Өсөн дэвших нээлттэй бодлого, тэгш боломжоор хангагдах
- Чөлөөт цагийг зөв зохицой өнгөрүүлэх сонирхолын клубуудад хамрагдах

# Ажилд сонгон шалгаруулах зарчим.

- Бид ажилтныг бүрдүүлэх, сонгон шалгаруулах функц дээрээ хүний нөөцийн нээлттэй бодлого баримтлан ажилладаг.
- Байгууллагын зорилго ажилтан таны зорилготой нийцэж байхаар мэдлэг, ур чадвартай ажил горилогчийг **"Зөв хүнийг, зөв албан тушаалд, зөв цагт"** сонгон шалгаруулж авахыг зорин ажиллаж байна.
- **Сонгон шалгаруулалт хийгдэх үе шат:** Анкет хүлээн авах -> Анкетын сонгон шалгаруулалт -> Шалгалт, тест -> Ярилцлага уулзалт -> Ажилд авах санал -> Нэткапиталжуулах сургалт

## Хүний нөөцийн сонгон шалгаруулалт



# 1+ жил ажилласан.

Netcapital Annual Report 2022



## Гар утас лизингээр авах

- ✓ Гар утас лизингээр авах шалгуур үзүүлэлт батлуулах тухай
- ✓ **Салбар/газрын захирал**
- ✓ **ХНУГ, СБГ**



## Гачигдалын тэтгэмж

- ✓ Нэг удаагийн мөнгөн тусламж
- ✓ **Салбар/газрын захирал**
- ✓ **ХНУГ, СБГ**



## Цалингийн зээлийн тодорхойлолт

- ✓ Цалингийн зээлийн тодорхойлолт өгөх шалгуур үзүүлэлт батлах тухай
- ✓ **Салбар/газрын захирал**
- ✓ **ХНУГ, ГЗ**



## Автомашины зээл

- ✓ Ажилчдад хөнгөлөлттэй автомашины зээл олгох тухай
- ✓ **Салбар/газрын захирал**
- ✓ **ХНУГ, ЗГ**

## ➤ Гүйцэтгэх удирдлагыг шагнаж урамшуулах.

Ажил олгогч нь үнэнч шударга хөдөлмөрлөж, ажилдаа тодорхой үр дүн, амжилт гаргасан ажилтанг дор дурдсан хэлбэрээр шагнаж урамшуулна. Үүнд:

- ❑ Компанийн нийт ажилтнуудын төлөөлөл 100%-н саналтайгаар тодорхойлсны дагуу ажлын үр дүнг харгалzan мөнгөн шагналаар шагнах;
- ❑ Эрхэлсэн ажилдаа өндөр амжилт гаргаж, дорвитой үр дүнд хургэсэн ажилтанд холбогдох заавар, журам, дүрмийн дагуу мөнгөн хэлбэрээр буюу биет зүйлээр шагнал олгоно.
- ❑ Хөдөлмөрийн өндөр амжилт гаргасан ажилтанг хүндэт алдар цол, одон медаль бусад шагналд тодорхойлох холбогдох байгууллагад тодорхойлолт, хүсэлт гаргана.
- ❑ Бусад зохицуулалтыг ажилтныг шагнах, шагналд тодорхойлох журмын дагуу хийнэ.

**Тогтмол зохион  
байгуулагддаг  
идэвхжүүлэлтийн  
ажлууд.**



### NET Academy

- Шинэ ажилтны сургалт
- Улирал бүр



### Net-Cup

- Спортын арга хэмжээ
- I-р улирал



### NET Naadam

- Баяр наадмын арга хэмжээ
- Үндэсний хувцсаараа гоёх



### NC-Summer Trip

- Зуны зугаалга, хөгжөөнт арга хэмжээ
- III-р улирал



### NET-Family

- Хүүхдийн баярын арга хэмжээ
- 05/31



### NC- New Year

- Шинэ жилийн арга хэмжээ
- 12-р сард

# Компанийн ололт амжилтууд.

Netcapital Annual Report 2022



- Машинaa унаад зээлээ ав бүтээгдэхүүнийг анх зах зээлд нэвтрүүлэв.
- Анхны салбараа Дорноговь аймагт нээж өргөжин тэлэв.
- 2009 оны Стандарт хэвшүүлэгч байгууллага.
- 2009 оны Топ-10 ББСБ



- 2011 оны 1 дүгээр улиралд компанийн дурмийн санг 335.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1.449 тэрбум төгрөгт хүргэв.
- Компанийн гүйцэтгэх захирал Н.Үндэрх 2011-2012 оны онцлох энтрепренер болов.
- 2011 оны Топ-10 ББСБ

- 
- Зээл, итгэлцэл, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлж үйл ажиллагаагаа эхлүүлэв.



- 
- Grapecity Mongolia LLC-ын Achidbanker системийг үйл ажиллагаандаа ашиглаж технологийн шийдлийг нэвтрүүлэв.
  - MXAYT-ийн Платинум гишүүн 2010 оны Топ-10 ББСБ



# Компанийн ололт амжилтууд.

Netcapital Annual Report 2022



- IT Zone ХХК-ийн "GreenERP" хүний нөөцийн системийг нэвтрүүлэв.
- Баянгол, Баянзүрх, Чингэлтэй дүүргүүд болон, Дархан, Эрдэнэт хотуудад шинэ салбаруудаа нээж томоохон тэлэлт хийв.
- Грэйпсити Монгол ХХК-ийн "Grape bank" банкны үндсэн системийг ўйл ажиллагаандaa нэвтрүүлж технологийн дараагийн шатанд гарав.
- 2013 оны Топ-10 ББСБ



- "Монголын ББСБ" холбооноос зохион байгуулдаг сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнд 3 жил дараалан түрүүлж шилжин явах цомыг мөнхлөв.
- 2015 оны Шилдэг татвар төлөгч

- 
- Бичил санхүүгийн Олон улсын зөвлөх Jonathan Hiebert-ийг менежментийн багтаа урьж ажиллуулав.
  - Гранд экспо ТОП-5 ББСБ нэгээр шалгарав.
  - 2012 оны Топ-10 ББСБ



- 
- Мост мони төлбөр тооцооны системийг нэвтрүүлж салбартаа анхны бэлэн бус гүйлгээний хэлбэрт 100% шилжив.
  - 2014 оны Шилдэг татвар төлөгч



# Компанийн ололт амжилтууд.

Netcapital Annual Report 2022



2016

- Гар утсанд сууриссан "Мобайл кредит" зээлийн эрх бүхий шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэв.
- Сүхбаатар дүүрэгт шинэ салбараа нээв.
- Автомашины лизингийн "ӨӨДӨӨ" бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай нэвтрүүлэв.



2018

- Нийгмийн хариуцлагын хүрээнд Арабын нэгдсэн Эмират улсад болсон Хүн төрөлхтний эв нэгдлийн билэг тэмдэг "Special Olympic" - ийн наадмын мэдээллийн ерөнхий ивээн тэтгэгчээр ажиллав.
- Нийгмийн хариуцлагын хүрээнд "ХЭЛ хязгаар ҮГҮЙ" төслийг хэрэгжүүлж OPEN WORLD сургалтын төвтэй хамтран алслагдсан дүүргийн 300-н хүүхдийг үнэ төлбөргүй АНГЛИИ хэлний сургалтад хамруулав.
- Санхүүгийн боловсрол олгох, сургалт үйлчилгээ явуулах зорилгоор НэтАкадеми ХХК-ийг үүсгэн байгуулж үйл ажиллагаа эхлүүлэв.

- 2016 оныг сургалтын жил болгож мэргэжлийн болон хувь хүний хөгжлийг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулж амжилтай хэрэгжүүлэв.



2017

- Нийгмийн хариуцлагын хүрээнд "10,000 инээмсглэл" төслийг амжилттай хэрэгжүүлэв.
- Сонгинохайрхан болон Чингэлтэй дүүрэгт шинэ салбарууд нээв.
- Ребрэндинг хийв.
- ББСБ холбооны "Оны шилдэг нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэгч байгууллага"
- Харилцагчидруу чиглэсэн "ӨӨРТӨӨ ЗОРИУЛАХ 60 МИНУТ" хөтөлбөрийг хэрэгжүүлэв.



2019

## **Компанийн ололт амжилтууд.**


Netcapital Annual Report 2022



- Улаанбаатар хотын Баянгол дүүрэгт “Хороолол” салбар шинээр нээгдэв.
  - Да Хүрээ авто худалдааны төвд шинэ салбараа нээв.
  - Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт “Сансар” салбар шинээр нээгдэв.



- CRM hubspot -г албан ёсны эрхтэйгээр нэвтрүүлэв.
  - Монгол Ипотекийн Корпорацитай Зээлийн багц худалдах, худалдан авах гэрээ байгуулж, эх үүсвэр татах Хамтын ажиллагааг эхлүүлсэн.
  - Төвийн нэгжийн үйл ажиллагаанд OKR, Scrum, JIRA-г нэвтрүүлж, ашиглаж эхлэв.



- Эрүүл уушги -10,000 маск аян
  - Аюулгүй гарц - Бага насны хүүхдүүдийг зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх аяныг Баянгол дүүргийн тээврийн цагдаагийн газартай хамтран ажиллав.
  - Финтек шийдэл бүхий цахим зээлийн үйлчилгээний NETAPP-ийг зах зээлд нэтрүүлэхээр төсөл эхлэв.



- “Амар” зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай нэвтрүүлэв.
  - Улаанбаатар хотод 22 авто худалдааны төвд шинэ салбараа нээв.
  - Компанийн бүтэц зохион байгуулалт тэлж, Шинээр 8 газар нэгжийг бий болгов.
  - Компанийн Алсын хараа, Эрхэм зорилго, Үнэт зүйлсээ шинэчлэн батлав.



# Компанийн ололт амжилтууд.

Netcapital Annual Report 2022



- Цахим мэнгөний зөвшөөрөл авав.
- Группийн актив хөрөнгө 2 дахин өсөлт хийв
- Компанийн Стратеги төлөвлөгөөнд "Balanced Scorecard" аргачлалыг ашиглаж эхлэв.



- Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэгт "Их Монгол" салбар шинээр нээгдэв.

- Финтек шийдэл бүхий цахим зээлийн үйлчилгээний NETAPP-ийг зах зээлд нэтрүүлэв



- Олон улсын банк санхүүгийн салбарын онлайн сэтгүүл болох "Global Banking & Finance Awards"-н 2021 оны шилдэг ББСБ болов.
- Хөрөнгө оруулалт, эх үүсвэр татан төвлөрүүлэх зорилгоор Шангри Ла оффисын 22 давхарт үйл ажиллагаа явуулж эхлэв.



# Компанийн ололт амжилтууд.

Netcapital Annual Report 2022



- Олон улсын санхүүгийн тайллагналын IFRS9 Стандартыг нэвтрүүлэхээр шийдвэрлэж, төсөл эхлэв.
- NetPay апликацийний шинэ хувилбарыг гаргаж, дансны хуулга дээр үндэслэн зээлийн оноо боддог боломжтой болов. Мөн төлбөр тооцооны боломжууд нэмэгдлээ.



- ToC Холбоонд гишүүн байгууллагаар элэж Компанийн Тогтвортой санхүүжилтийн (ToC) бодлогыг баталлаа.
- Засаглалын үнэлгээгээр ТОП-5 ББСБ-н 1 болов.
- ISO27001:2013 мэдээллийн аюулгүй байдлын стандартыг нэвтрүүлэв.
- Компанийн 27 салбарт OKR, Scrum, JIRA-г бүрэн нэвтрүүлэв.

- Олон улсын Чанарын удирдлагын тогтолцооны ISO9001:2015 нэвтрүүлсэн анхны ББСБ болов.
- Компанийн үндсэн систем буюу корбанкийг дотооддоо хөгжүүлж, нэвтрүүлэхээр шийдвэрлэж, төсөл эхлэв.
- Орон нутагт шинээр 12 салбарыг зэрэг нээв.
- Улаанбаатар хотод "Парк-Од" салбар, "Гранд Плаза" салбар, "Гэгээнтэн" салбар шинээр нээгдэв.



- Харилцагчийн үйлчилгээний газрыг шинээр байгуулав.
- Дижитал зээлийн салбарыг шинээр нээв.
- Machine learning аргачлалаар орон сууцны үнэлгээг таамагладаг болов.
- Гаалтай лизинг бүтээгдэхүүний процесс автоматжуулалтыг амжилттай хийж, 30 минутанд зээл олгодог боллоо.



## Дижитал шилжилт.

**NetCore төсөл хэрэгжиж эхлэв.**



Харилцагч, зээл, төлбөр тооцоо, гүйлгээ зэрэг ББСБ-ын үндсэн үйл ажиллагаанд шаардлагатай мэдээллийг бүртгэлжүүлэн боловсруулж, тайлагнах суурь системийн төслийг эхлүүлэв.



## Дижитал шилжилт.

NetWallet –ийг амжилттай нэвтрүүллээ.

Бүх төрлийн төлбөр тооцоо, шилжүүлэг, гүйлгээ зэргийг хийх бүрэн боломжтой цахим төлбөрийн хэрэгсэл юм.



# ОНЦЛОХ АЖИЛ.

## ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙГДСЭН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

- ✓ Зээлийн багцын чанарын зорилтыг бүрэн хангаж, Нийт багцад Чанаргүй зээлийн эзлэх хувийг ББСБ-ын салбарын дунджаас бага түвшинд барьж ажиллалаа.
- ✓ Зээлдэгчийн хувийн хэргийг хадгалах цахим дэд системийг хөгжүүлж, ашиглалтанд оруулав.
- ✓ Харилцагчийн дансны орлогыг NetPay аппли케йшнээр дамжуулан дотоод системд татаж, зээлийн судалгаанд ашиглах боломжтой болсон. Ингэснээр НДШ төлдөггүй харилцагчдад зээлийн үйлчилгээ үзүүлэх боломжтой болов.
- ✓ Хувь хүний нууцын тухай хуультай холбоотой хурууны хээ ашиглан ХҮР системээс авдаг байсан мэдээллийг ДАН, E-Mongolia системүүдээр харилцагчаа баталгаажуулсны үндсэн дээр авдаг болсон.
- ✓ “Зээлийн мэдээллийн сан”-ийн үйлчилгээ үзүүлэгч Бүрэн Скор ХХК-ийн системтэй интеграц хийв.
- ✓ Харилцагчийн зээлийн эргэн төлөлт болон бусад төлбөр тооцоог дамжуулахаар Монголбанкны АСН системийг бүрэн нэвтрүүлэх, бэлтгэл ажлыг хангаж дууссан.
- ✓ Гаальтай лизингийн зээлийн бүтээгдэхүүн шийдвэрлэх системийн автоматжуулалт хийж, зээлийг 30 минутанд олгодог болов.
- ✓ Зээл авсан харилцагч нартаяа зориулж “Эко Систем” бий болгохоор БГД, БЗД, ХУД, СБД-т байршилтай авто угаалга, сэлбэг, засвар үйлчилгээний нэр бүхий 16 байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, харилцагч нартаяа хөнгөлөлттэй лоялти үйлчилгээг үзүүлж байна.
- ✓ 16 байгууллагын жагсаалт:  
<https://www.netcapital.mn/loyalty>

Дижитал банкийг таны гарг





# Тогтвортой санхүүжилтийн (ToC) бодлогыг баталлаа.

Netcapital Annual Report 2022



Зарчим 1

**БАЙГАЛЬ ОРЧНОО  
ХАМГААЛАХ**



Зарчим 5

**САНХҮҮГИЙН  
ХҮРТЭЭМЖИЙГ ДЭМЖИХ**



Зарчим 2

**ХҮНИЙ ЭРХ,  
НИЙГМИЙГ ХАМГААЛАХ**



Зарчим 6

**ИЛ ТОД БАЙДАЛ,  
ХАРИУЦЛАГЫГ ДЭМЖИХ**



Зарчим 3

**СОЁЛЫН ӨВИЙГ  
ХАМГААЛАХ**



Зарчим 7

**МАНЛАЙЛАН  
ҮЛГЭРЛЭХ**



Зарчим 4

**"НОГООН ЭДИЙН ЗАСАГ"-ИЙН  
ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ**



Зарчим 8

**ЁС ЗҮЙТЭЙ САНХҮҮЖИЛТ,  
КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ ДЭМЖИХ**

## **ОНЦЛОХ АЖИЛ.**


### **Тогтвортой санхүүжилтийн бодлого.**

Тогтвортой санхүүжилтийн бодлого болон БОНЗЭУ-ын журмыг баталж, үйл ажиллагаандаа тогтвортой санхүүжилтийг 2023 оноос нэвтрүүлэхээр ажиллаж байна.

НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтыг хангах Монгол Улсын нэгдэн орсон баримт бичгийн хүрээнд Нэткапитал Финанс Корпораци ББСБ нь харилцагчдад Хөрөнгө оруулалт, зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх, дотоод үйл ажиллагааны санхүүгийн шийдвэр гаргахдаа байгаль орчин, нийгэм, засаглал, эдийн засгийн үр ашгийг тэнцвэртэйгээр авч үзэж, дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулж, байгалийн нөөцийг зохистой хэрэглэх хойч үедээ үлдээхэд хувь нэмрээ оруулан ажиллах эхлэл тавигдav.

Түүнчлэн, урт хугацаанд олон улсын зах зээлийн хөрөнгө оруулалт, томоохон төслүүдэд хамрагдах замаар харилцагч болон байгууллагын хамтын ажиллагаа тогтвортой ёсөх боломж бурдэх юм.

Тогтвортой санхүүжилтийн бодлогыг 2022 оны 11 сард компанийн ТУЗ баталлаа.



# ОНЦЛОХ АЖИЛ.

## Улаанбаатар хотын салбар, нэгж

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй жижиг дунд, бичил бизнес эрхлэгч, зээл хүсэгч харилцагч нартаяа бид улам ойртож 2022 онд **шинээр дараах 2 салбарыг** нээж, 50+ ажлын байрыг бий болголоо. Ингэснээр Улаанбаатар хотод **нийт 12 салбар** үйл ажиллагаа явуулж байна.


✓ Парк-Од салбар



✓ Гэгээнтэн салбар



Дижитал банкийг таны гартаа



## Онцлох ажил.

Орон нутагт шинээр 12 салбарыг зэрэг нээв.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй жийжиг дунд, бичил бизнес эрхлэгч, зээл хүсэгч харилцагч нартаа бид улам ойртоож 2022 онд шинээр 12 салбарыг зэрэг нээж, 100+ ажлын байрыг бий болголоо. Ингэснээр Орон нутгийн 15 аймагт нийт 15 салбар үйл ажиллагаа явуулж байна.



Дижитал банкийг таны гарг



## Онцлох ажил.

### Дижитал зээлийн салбар

Дижитал зээлийн үйлчилгээ авдаг харилцагч нартаяа улам ойртоож, бид 2022 онд “Дижитал зээлийн салбар”-ыг шинээр байгуулж, захирал, ахлах зээлийн зээлийн ажилтан, зээлийн ажилтан, үйлчлэгч гэсэн 25+ ажлын байрыг шинээр бий болголоо.

*Дижитал-бараа бүтээгдэхүүнд харилцагчийн дансны хуулгаас орлогыг баталгаажуулж, зээлийн эрхийг автоматаар тогтоодог боллоо.*




## Онцлох ажил.

### Харилцагчийн үйлчилгээний газар

2022 онд шинээр байгуулж, харилцагчийн үйлчилгээ, харилцагчийн сэтгэл ханамж, гомдол, саналыг түргэн шуурхай шийдвэрлэхээр ажиллаж байна.

Харилцагчийн Гомдол шийдвэрлэх дундаж хугацаа 48 цаг байсныг 1.2 цаг болгож буурууллаа.

Дижитал банкийг таны гарта





## Онцлох ажил.

Компани үйл ажиллагаандаа хэрэгжүүлж буй Олон улсын Стандартууд.

1. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ - IFRS9
2. ISO 9001:2015 ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО
3. ISO/IEC 27001:2013 МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО



### IFRS9 стандарт нэврүүлж байна.

- САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ - IFRS9

Компани нь 2022 оны 3 дугаар улиралд Армени улсад байрлалтай Grant Thornton Advisory LLC-с зөвлөх үйлчилгээ аван СТОУС 9-ийг 2023 онд хэрэгжүүлэхээр холбогдох бэлтгэл ажлыг бусад газартай хамтран бэлтгэж дуусгасан. Тус стандартын хүрээнд компани нь шатлал бүрээр үнэ цэнийн бууралтыг тооцож олон улсын стандартыг 2023 оноос эхлэн хэрэгжүүлж эхэллээ.

IFRS9 стандартыг нэвтрүүлэхээр Армени улсад байрлалтай Grant Thornton Advisory LLC-с зөвлөх үйлчилгээтэй хамтран ажиллаж байна.

## Онцлох ажил.

ISO 9001:2015 стандартын магадлан аудит амжилттай хийгдлээ.



### • ISO 9001:2015 ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

Компани уг стандартыг Зээл, Итгэлцэл, Гадаад валютын арилжаа, Цахим төлбөр тооцоо ба мөнгөн гүйвуулгын үйлчилгээндээ амжилттай нэвтрүүлэн, 2022 онд Австрали улсын TQCSI баталгаажуулалтын компаниар Магадлан 1 аудит хийлгүүлж сертифактын хугацаагаа дахин 1 жилээр амжилттай сунгалаа.

ISO 9001:2015 Стандартын PDCA циклыг хангаснаар:

1. ЧУТ-ны шаардлагыг бүрэн ханган ажиллаж, шат бүрт хяналт, стандарт тогтолцоотой болов;
2. Хэрэглэгчийн сэтгэл ханамжид сууринсан бүтээгдэхүүн үйлчилгээг гаргаж, тасралтгүй сайжруулдаг болов;
3. Харилцагчийн үйлчилгээний чанарыг тогтмол хэмжиж, сайжруулалтын хэрэгжилтийг шуурхай ханган ажилладаг болов;
4. Эрсдэл ба боломжуудыг урьдчилан тооцож харилцагчийн хэрэгцээг бүрэн хангасан чанартай бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэдэг болов;
5. Байгууллагын гадаад, дотоод орчны шинжилгээг Олон улсын аргачлалын дагуу хийж, стратеги төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлдэг болов;
6. Олон улсын зах зээлд хүлээн зөвшөөрөгдж, хөрөнгө оруулалт, эх үүсвэр, томоохон төслүүдэд бүрэн хамрагдах боломжтой болов;

## Онцлох ажил.

ISO 27001:2013 стандартыг шинээр нэвтрүүллээ.



### • ISO/IEC 27001:2013 МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

Финтек зээлийн үйлчилгээ, Зээлийн скоринги болон аппликашн хөгжүүлэхэд мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилготойгоор ISO/IEC 27001:2013 стандартыг амжилттай нэвтрүүллээ.

ISO/IEC 27001:2013 Стандарт нэвтрүүлснээр:

1. Санхүүгийн Зохицуулах Хорооны шаардлагыг бүрэн хангасан Финтек зээлийн үйлчилгээг харилцагчдад үзүүлэх
2. Компанийн хэмжээнд Мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг баримталж үйл ажиллагаанд нэвтрүүлэх
3. Компанийн ажилтнууд зайнаас ажиллах болон зөөврийн төхөөрөмжийн хэрэглээний аюулгүй байдлыг хангах
4. Үндсэн болон үйлдлийн системүүдэд учрах эрсдэлийг бууруулж хэвийн үйл ажиллагааг хангах
5. Мэдээллийн нууцлал, үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг хамгаалах зорилгоор Криптографын бодлогыг нэвтрүүлэв
6. Харилцагчийн болон дотоод мэдээллийг зөвшөөрөлгүй задруулах, өөрчлөх, устгах, хууль бусаар нэвтрэн орох зэргээс урьдчилан сэргийлэх
7. Харилцагч болон байгууллагын мэдээллийг гадны халдлага, хортой кодоос хамгаалах
8. Кибер болон сүлжээнийн аюулгүй байдлын хамгаалалтыг тогтмол сайжруулах
9. Компанийн бизнесийн тасралтгүй ажиллагааны тогтолцоонд мэдээллийн аюулгүй байдлын тасралтгүй байдлыг шингээх
10. Хууль, эрх зүйн акт, зохицуулалт болон гэрээний үүрэг, түүнчлэн аюулгүй байдлын шаардлагыг зөрчихөөс урьдчилан сэргийлэх
11. Олон улсын зах зээлд хүлээн зөвшөөрөгджэх эх үүсвэр, хөрөнгө оруулалт босгох, томоохон төслүүдэд бүрэн хамрагдах боломжтой боллоо.

# Дотоод аудитын тогтолцоо

Netcapital Annual Report 2022

## ➤ Дотоод аудитын зорилго.

Дотоод аудитын газар нь “Нэткапитал Финанс корпораци ББСБ” ХХК-ийн бизнесийн үйл ажиллагаанд баталгаажуулалт болон зөвлөх үйлчилгээгээр дамжуулан Компанийн засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үр дүнтэй байдлыг хараат бус, бодит байдлаар үнэлнэ.

## ➤ Дотоод аудитын тогтолцоо.

1. Дотоод аудитын газар нь хараат бус байх ба ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороонд харьялагдаж, тайлагнаж, мөн дараахыг шийдвэрлүүлнэ. Үүнд:
  - ✓ Дотоод аудитын дүрэм болон журмыг батлах;
  - ✓ Эрсдэлд сууриссан дотоод аудитын жилийн төлөвлөгөөг батлах;
  - ✓ ДАГ-ын төсөв болон нөөцийн төлөвлөгөөг батлах;
  - ✓ Менежментийн талаас ДАГ-ын үйл ажиллагааны хамрах хүрээ;
2. ДАГ нь нэгж аудитыг сонгох, аудитын хамрах хүрээ, зорилго, шалгуур үзүүлэлт, аудитын давтамж, тайлангийн агуулгыг тодорхойлохдоо бусад газрын нөлөөллөөс ангид байна. Ингэснээр хараат бус, бодит байдлыг бий болгоно. Хараат бус, бодит байдал алдагдсан эсвэл алдагдах нөхцөл үүссэн тохиолдолд Аудитын хороонд мэдэгдэнэ.

## ➤ Дотоод аудитын бүтэц ба зохион байгуулалт.

1. ДАГ нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороонд шууд харьялагдаж тайлагнана.
2. ДАГ нь газрын захирал, ахлах аудитор, аудитор гэсэн бүтэцтэй байна.
3. ДАГ нь Олон улсын дотоод аудитын стандарт ба ёс зүйн дүрэм, Дотоод аудитын газрын бодлого, дүрэм, журамд нийцэж ажиллана.

## ➤ Дотоод аудитын чиг үүрэг.

1. ДАГ нь эрсдэлд сууриссан аудитын орчныг тодорхойлж, Гүйцэтгэх захирал ба ТУЗ-ийн санал дээр үндэслэн дотоод аудитын жилийн төлөвлөгөөг гаргах ба Аудитын хороонд танилцуулж батлуулна.
2. ДАГ нь Группт нөлөөлж болзошгүй шинээр үүсч буй чиг хандлага болон асуудлуудыг анхааралдаа авч, Гүйцэтгэх Удирдлага болон шаардлагатай холбогдох талуудад мэдэгдэнэ.
3. Аудитын илэрц болон зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжээгүй зөвлөмжүүдийн талаар ТУЗ-д тайлагнана.
4. ДАГ нь дотоод аудитын бүх талыг хамарсан чанарын баталгаажуулалт, тасралтгүй сайжруулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байна. Чанарын баталгаажуулалт болон тасралтгүй сайжруулалтын хөтөлбөрийг 5 жил тутамд хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлнэ.
5. Аудитын жилийн төлөвлөгөөнд тусгасан аудит тус бүрийн зорилт, хамрах хүрээ, нөөцийн хуваарилалт, хөтөлбөр, шалгалтын үр дун, аудитын дүгнэлт болон зөвлөмжийг холбогдох талуудад хүргүүлнэ.

# Эрсдэлийн удирдлага

Netcapital Annual Report 2022

## ➤ Эрсдэлийн удирдлага

Группийн үнэ цэнийг хамгаалах зорилгоор эрсдэлийн удирдлагын багийг бүрдүүлэн, ирээдүйд учирч болох эрсдэлийн төрлийг тодорхойлж, хянаж, удирдан ажиллаж байна. Эрсдэлийг удирдсанаар инновацийг дэмжих, гүйцэтгэлийг сайжруулах боломж бүрдсэн.

## ➤ Эрсдэлийн удирдлагын засаглал, тогтолцоо

Групп нь эрсдэлийн удирдлагын засаглалаа Гүйцэтгэх захирлын эрх үүрэгт хамаарах хороодоор дамжуулан хэрэгжүүлж байна.

Группийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь хамгаалалтын гурван бусийн зарчим баримтлах ба эрсдэлийг хариуцах, хянах удирдах, засаглалыг бүрдүүлэх чиг үүргүүдийг хуваарилан ажилладаг.

## ➤ Эрсдэлийн удирдлагын хорооны үйл ажиллагаа

Гүйцэтгэх захирлын эрх үүрэгт хамаарах эрсдэлийн удирдлагын хороо нь батлагдсан дүрэмд заасан бүрэлдэхүүн, давтамж, хэлэлцэх асуудлын дагуу 14 хоног тутам хуралдаж, эрсдэлийг хэлэлцэн, шийдвэрлэх арга хэмжээ авч ажилладаг.

2022 онд нийт 22 удаа хуралдсан бөгөөд үүсч буй эрсдэлийг шийдвэрлэх, хяналтын тайланг хэлэлцэх, эрсдэлийн хязгаар лимитийн хэрэгжилтийг хянах, МУТСТ хууль, журам болон Зохицуулагч байгууллагын шалгуур, шаардлагыг хангуулах гэх мэт дүрэмд заасан хэлэлцэх шаардлагатай асуудлуудыг бүрэн хамруулж, шийдвэрийн хэрэгжилтийг Эрсдэлийн удирдлагын газраас хянаж байна.

## ➤ Эрсдэлийг удирдах баримт бичгүүд

Группийн нийт эрсдэлийг дараах 8 ерөнхий төрөлд ангилж байна. Үүнд:

Стратегийн эрсдэл, Санхүүгийн эрсдэл, Зээлийн эрсдэл, Үйл ажиллагааны эрсдэл, Нийцлийн эрсдэл, Нэр хүндийн эрсдэл, Мэдээллийн технологи, аюулгүй байдлын эрсдэл , Байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн удирдлага

Дээрх эрсдэлийн төрөл тус бүрт нь эрсдэлийг удирдах журам болон арга аргачлалуудыг боловсруулан мөрдөж байна.

## 1. Стратегийн эрсдэлийн удирдлага

Группийн стратеги төлөвлөгөөнд нөлөөлөх гадаад дотоод орчны эрсдэл болон боломжийг Гүйцэтгэх удирдлагын багаар жил бүр шинэчлэн тодорхойлж, авах арга хэмжээг төлөвлөдөг. Хэрэгжилтийг OKR төлөвлөгөөний гүйцэтгэлд үндэслэн хянах замаар ханган ажиллаж байна.

## 2. Санхүүгийн эрсдэлийн удирдлага

Групп нь Зохицуулагч байгууллагаас тавьдаг зохистой харьцааны шалгуур болох өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, актив хөрөнгийн төвлөрөл, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө болон үндсэн хөрөнгийн үзүүлэлтүүдийг хүлээн зөвшөөрөх хэмжээнд ханган ажиллалаа.

### **3. Зээлийн эрсдэлийн удирдлага**

2022 он нь дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахалаас үүдэлтэй сөрөг үр дагаврууд үргэлжилж, иргэдийн худалдан авах чадвар буурах, цар тахалтай холбоотой зээлийн нөхцөл, ангилалд үзүүлсэн хөнгөлөлт дуусах зэрэг хүчин зүйлүүдээс шалтгаалан зээлийн эрсдэлийг онцгойлон удирдах шаардлага үүссэн.

Групп нь Зээлийн эрсдэлийг удирдах журмаар зээлдэгч, зээлийн бүтээгдэхүүн, барьцаа хөрөнгийн эрсдэлийн хязгааруудыг тодорхойлон зээлийн оновчтой багц бүрдүүлэх, зээлийн эрсдэлийн дохиог эрт илрүүлэх, зээлдэгчийг таних скорингт тасралтгүй сайжруулалт хийх, барьцаа хөрөнгийн үнэлгээг автоматжуулж, хүнээс хамаарсан эрсдэлийг бууруулах зарчим баримтлан ажиллаж байна.

### **4. Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага**

Үйл ажиллагааны эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ISO9001:2015 стандартын дагуу SIPOS аргачлалаар тодорхойлсон Группийн хэмжээний нийт процессын эрсдэлийг тодорхойлж, шийдвэрлэхээр төлөвлөсөн хариу арга хэмжээний хэрэгжилтийг улирал бүр хянан удирдаж байна.

### **5. Нийцлийн эрсдэлийн удирдлага**

Групп нь МУТСТ хууль болон СЗХ-оос гаргасан МУТСТ үйл ажиллагааны журмын дагуу Нийцлийн эрсдэлийг удирдах журмыг боловсруулан батлуулж, тогтолцоог бүрдүүлэн ажиллаж байна.

Эцсийн өмчлөгч тодорхойлох, санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хориг жагсаалтад орсон харилцагчийг таних зэргээр МУТСТ хууль болон СЗХ-ны журамд нийцэхгүй, эрсдэлтэй харилцагчийг таних автомат системийг нэвтрүүлсэн.

### **6. Нэр хүндийн эрсдэлийн удирдлага**

Группийн талаарх сошиал дахь эерэг, сөрөг мэдээллийг автоматаар цуглуулах програмыг үйл ажиллагаандаа ашиглаж, нэр хүндийн эрсдэлээс урьдчилан сэргийлж байна.

### **7. Мэдээллийн технологи, аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага**

ББСБ-ын салбар өргөжихийн хэрээр байгууллагууд технологийн дэвшил, мэдээлэл солилцох, боловсруулах хурдаар өрсөлдөж байгаа тул Мэдээллийн технологи, аюулгүй байдлын эрсдэл шууд хамааралтайгаар нэмэгдэж байна.

Иймд байгууллагын үнэ цэнтэй мэдээллийн нууцлалтай, хүртээмжтэй, бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог /МАБУТ/ хортой кодын эсрэг хяналт, физик нэвтрэлтийн хяналт, системийн эмзэг байдлын хяналт, эрхийн зохицуулалт, логийн удирдлага, digital forensic гэх мэт хяналтуудаар дамжуулан бий болгож, эрсдэлийг удирдаж байна. Мөн үйл ажиллагаандаа ISO27001:2013 стандартыг нэвтрүүллээ.

### **8. Байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага**

- Групп нь байгаль орчин, олон нийтэд сөрөг нөлөө үзүүлэх үйл ажиллагаа эрхэлдэггүй бөгөөд хориглох үйл ажиллагааны чиглэлийг "Эрсдэлийн удирдлагын бодлого"-оор баталдаг.
- Нийгмийн хариуцлагын хүрээнд олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаанд тусгайлан төсөв баталж, хэрэгжүүлж байна.
- Хөдөлмөр, эрүүл мэнд аюулгүй байдлын хувьд бүх ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажлын байрны хэвийн нөхцөлөөр бүрэн хангаж, эрсдэлээс сэргийлдэг.
- 2022 онд бид Тогтвортой санхүүжилтийн үйл ажиллагааг нэвтрүүлж, ТоC бодлого болон ТоC бодлогыг хангах зорилгоор "Байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн удирдлагын журам"-г баталж, аргачлал, систем хөгжүүлэлтийг бий болгон, хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Уг журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэнээр 50 сая төгрөгөөс дээш хэмжээтэй, 12 сараас дээш хугацаатай бүх бизнесийн зээл авч буй харилцагчдын эрсдэлийг үнэлж, эрсдэл өндөртэй харилцагчид эрсдэл бууруулах шаардлагыг тавьж, ТоC-н зарчмыг дэмжиж ажиллаж байна.



# ANNUAL REPORT

## NETCAPITAL 2022



**NET CAPITAL**  
financial group